

**Орчуулсан: Сүрэнжавын  
БҮЖИНЛХАМ**

*МУИС, ШУС, Философи шаашин  
судлалын тэнхимийн багш*

*Этвёш Лорандын Их сургуулийн,  
Философийн Институтийн докторант*

**ОРЧУУЛАГЧИЙН ҮГ:**

“Нийгмийн шинжлэх ухааны философи” хичээлийн явцад ХХ зууны II хагасын Аналитик философийн томоохон төлөөлөгч болох Хилари Патнэмын “Beyond fact/value distinction” хэмээх богино бичвэртэй танилцсан юм. Хичээлийн явцад ч, хожим нь шинжлэх ухаан, мэдлэгийн талбарын талаар яриа өрнүүлэх явцад ч баримтаар шалгаж, үнэн эсвэл худал хэмээх үнэний утгатай байх мэдлэг л үнэ цэнтэй гэх позитивист хандлага нийтэд түгээмэл болохыг ажигласан болно. Гэтэл позитивистуудын төсөөлдөг лугаа адил шинжлэх ухаан бол дан үнэн бодомж буюу баримтын цуглуулга мөн үү? хэмээн асуувал та нэгдсэн хариулт авч чадахгүй. Давын өмнө шинжлэх ухаанд үнэлэмж-нэвчмэл үү? Энэ байдал нь обьектив шинжлэх ухааны мэдлэгтэй зөрчилдөх үү? зэрэг асуултуудад хариулах шаардлага тулгарах аж. Дээрх асуултад өгөх өөрийн хариултаа Хилари Патнэм “Баримт/Үнэний хослолоос чанагш өнгийхүй” гэх энэхүү бичвэртээ өгсөн байдаг. Үнэлэмжийн мэдлэгийн талаарх тогтсон хандлага, дадсан бодлыг тань түнших жинтэй өгүүлэл байж мэдэх юм хэмээн сонгон орчууллаа. Хэрэв та Хилари Патнэмын илүү дэлгэрэнгүй, иж бүрэн эргэцүүллийг уншихыг хүсвэл “Reason, Truth and History” гэх номыг нь санал болгоё.

**БАРИМТ / ҮНЭЛЭМЖИЙН  
ХОСЛОЛООС  
ЧАНАГШ ӨНГИЙХҮЙ<sup>1</sup>**

Хилари Патнэм

Хэдэн жилийн өмнө нэгэн үдэшлэгийн үеэр эзэгтэйн хэлсэн үг сэтгэлд хоногшжээ. Иран дахь Америкийн Элчин сайдын яаманд болсон хэргийн яг дараахан тул бүгд л барьцаалагдсан хүмүүст санаа зовниж, үймэрч бухимдсан байв. Үдэшлэгийн дунд хэрд эзэгтэй маань “шинжлэх ухаан ертөнцийг хөндий хүйтэн механизм болохыг хэлж өгснөөс” үүдэн юунд ч тайтгарах аргагүй болсон *өөрсдийнхөө* талаар дурдахын хамт, Исламын шашинд итгэх үлэмж итгэлээс хүртэх Иранчуудын тайтгарал тайвшралд *атаархангүй* явдаг гэдгээ уудалсан юм.

*Шинжлэх ухаан ертөнцийг хүйтэн хөндий механизм болохыг зааж хэлсэн:* Ницшегийн гутранги ертөнцийг үзэх үзэл нь “Шинжлэх ухаан бидэнд номлодог” хэмээх өмнөтгөлөөр эхэлдэг билээ. Мэтью Арнолд “Бодолд төрж, бидэнд мэдэгдсэн зүйлсийн хамгийн шилдэг”-ийн тухай нот итгэлтэйгээр ярьсны дараа хэнд маань ч тийм их итгэл төрөөгүй юм даг. Түүнчлэн ноён Арнолд “бодолд төрж, бидэнд мэдэгдсэн зүйлсийн хамгийн шилдэг” нь бүхэлдээ, үгүй ядаж хамгийн чухал хэсэг нь шинжлэх ухаан гэж боддоггүй гэдгээ ч илэрхийлээд амжсан юм. Намайг мэдэх хүмүүс аль хэдийнээ тааварлаа биз ээ. Би ч “Шинжлэх ухаан бидэнд номлодог” тухай үндэслэлийг чихний хажуугаар зүгээр өнгөрүүлээгүй бөгөөд өргөн хүрээг хамарсан хэлэлцүүлэг өрнүүлээд амжсан юм. Гэхдээ л бараг XVIII зууны үеийн оройн хоолны ярианы сэдэв болох тухайн үг санааны үзүүрт үлдэж хоцорчээ.

<sup>1</sup> Putnam H. (1982) Beyond the Fact/Value Dichotomy. In: Tauber A.I. (eds) Science and the Quest for Reality. Main Trends of the Modern World. Palgrave Macmillan, London. [https://doi.org/10.1007/978-1-349-25249-7\\_15](https://doi.org/10.1007/978-1-349-25249-7_15)

Хэдэн сарын дараа уг явдлыг Рожерс Албриттонд хэлтэл тэрээр эзэгтэйн үгийг “шашинжсан онцлолт (**religious remark**)” байна гэж билээ. Мэдээж түүний зөв л дөө. Ертөнцийн тухай үзэл нь ёс суртахууны шинж талыг(aspects) багтааж байж л бүрэн дүүрэн байдаг гэх санааг шашин алгаа дэлгэн хүлээн авдаг гээ. Түүнчлэн эзэгтэйн хэлсэнчлэн шинжлэх ухаан шинэ шинэ, уйтгартай дүнсгэр нээлтүүдийг өмнө маань өрж тавьдаг бол дээрх үг үнэхээр л шашинжсан байж таарна.

Манай эзэгтэйн хэлсэн үгийн мадаг нь хаана байгааг Рамсей алдарт лекцийнхээ төгсгөлд тун урнаар илэрхийлсэн байдаг юм. Рамсейн энэ санаа ч тун түгээмэл:

“Ертөнцийн тухай миний зураглал хэмжих ёстой хэв загвар байдлаар биш харин харах өнцгөөс минь хамааран бүрэлддэг билээ. Уг зураглалын маань сууринд, юун түрүүнд хүн төрөлхтөн зогсож, алсын одод гурван зоосны дайтай л жижигхэн санагддаг юм. (*Од эрхэс*) хүн зарим тохиолдолд амьтны сэрэл мэдрэмжийн хэрэг явдалд хэсэг бусгаар нөлөөлөх тухай тун чиг ээдрээтэй тайлбараас бусдаар бол одон орон судлалд би нэг их итгээд байдаггүй л дээ. Уг харах өнцөг маань орон зай төдийгүй цаг хугацаанд ч хамаатай. Цагийн аясаар ертөнц хөрж, бүгд л үхнэ. Гэхдээ тэр хүртэл уртаас урт хугацаа зурайна. Тэрхүү холхи ирээдүйг одоод үнэлвээс үртэсний чинээнд ч хүрэмгүй. Нөгөөтээгүүр ирээдүй таг хоосон гэдгээс одоогийн үнэ цэн буурах учиргүй. Зураглалын минь суурь болох хүн төрөлхтөн сонирхол татам агаад нийтээрээ бишрэл төрүүлэм. Би ертөнцийг дор хаяж л энэ цаг мөчид таатай, сэтгэл хөдлөм газар гэж боддог. Та орчлон хорвоог уйтгар гунигтай гэж үзэж мэдэх л юм. Тийм болбоос харамсаж буйгаа илэрхийлье. Та намайг үл ойшоож болно оо. Гэхдээ надад ийнхүү харамсах шалтгаан байгаа бол танд алга. Аливаа баримттай дүйцэх мэдрэмжээс

тань минийх ондоо байвал л танд намайг үл ойшоох шалтгаан гарах билээ. Гэхдээ үнэн хэрэгтээ хэн хэний маань мэдрэмж баримттай хэв зохицон дүйцэхгүй л дээ. Баримт өөрөө муу юм уу сайн байна гэж байдаггүй. Баримтаас үүдэн би догдолж байхад та гутарч байгаа л хэрэг. Нөгөө талаас надад таныг өрөвдөх шалтгаан бий. Учир юу гэвээс хямарснаас хөөрч догдлох нь илүү таатай бөгөөд, таатайгаар барах уу ажил хэрэгт ч нэмэртэй билээ.”<sup>2</sup>

Лекцийн эзэн 22 настай Рамсейгээс илүүгээр амьдралтай овоо дориун танилцаж, орчлонгийн ороо бусгаатай нүүр тулсан нэгэн (Рамсейгийн илтгэлээ хүргэж байсан 1925 оны Англиас хэд хэдэн дайн, олныг хамарсан өлсгөлөн, тоталитаризм бүхий өнөөгийн дэлхий ертөнц тэс өөр төдийгүй, торгомсог мэдрэмжтэй зохиолчийн бидэнд сануулж буй орчлон хорвоогийн ээдрээ нугачаанаас дунджаас дээгүүр амьдралтай нэгэн ч зайлсхийж чадахгүй билээ) бол хөхин баясахаасаа илүү гутарч гуних биз. Нэмж хэлэхэд Рамсей хорин долоохон насандаа мөнх бусыг үзүүлсэн нь миний хувьд уйтай хэрэг лав мөн.

Гэхдээ анзаар даа. Рамсейгийн лекцээс ишлэлсэн миний хэсэгхэн ишлэлээс, “шинжлэх ухаан бидэнд номлодог” гэх санаа тодорч товойн гарч ирж байгааг, бид өөрсдийн зөв гэдэгтээ хэр итгэлтэй байгааг анзаар даа. Орчин цагийн нээлтүүд уйтгар гуниг дагуулж болох ч ядахдаа л *элдэв бусад домгоос ангид* нээлтүүд юм даа. Ертөнц аймшигтай аваас үүнийг өөдрөгөөр харж байсан эцэг өвгөдийнхөө “*мунхаглалыг*”, тэдний итгэж, нандигнаж байсан бүхэн худал хуурмаг, өөдлөөд өөдлөөд мухар сүсэг байсан гэдгийг бид лавтайяа мэдэж байна.

Энэ явдал бидний хамраа сөхсөн, ихэрхүү занг дэвэргэх нь дамжиггүй. Эзэн тэнгэрийн уг чанар нууцлаг, түүний зорилго далд, түүний бүтээл-байгаль ч

<sup>2</sup> Cf. Frank Plumpton Ramsey, *Epilogue*, in *There is Nothing to Discuss* in *Foundations of Mathematics*, ed. by R.B. Braithwaite (New York: Harcourt Brace, 1931), pp. 291-292.

чандын чанад нууцыг тээдэг гэж уламжлал ёсоор үздэг. Будаг нь ханхалсан шинэхэн үзэл маань үнэн хэрэгтээ бидний мэдлэг туйлын, эцсийн биш гэдгийг, ертөнцийн тухай зураглал маань ирээдүйд олон талаар өөрчлөгдөнө гэдгийг, шинжлэх ухааны шинэ шинэ нээлтүүд өнцөг булан бүрт эзэн сууна гэдгийг, гэхдээ өргөн зураглалаараа бид юмс үнэн хэрэгтээ юу болохыг танин мэдэж чадна гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

“Ертөнц бол хөндий хүйтэн механизм” бөгөөд тухайлж хэлбэл бид азаар үүссэн дайвар бүтээл нь. Үнэлэмж гэдэг бол мэдрэмж төдий л зүйл. Дээр уншсан лекцийнхээ өөр нэг хэсэгт Рамсейгийн хэлсэнчлэн “Бид объектив сайны тухайд аль хэдийн санал нэгдэж, Эзэн тэнгэрийн оршихуйтай хамтатган, хэлэлцүүлэг ярианаасаа хассан гэдэгтэй ихэнх маань санал нэгдэх биз ээ. Алдарт теологи болон туйлын ёс зүй хоёр бол судлагдахуун үгүй талбарууд гэдгийг бид ойлгосон” аж.

Бидний бардамналыг дэмнэх энэхүү мөрүүдийг хэтрүүлэн үнэлж боломгүй гэж бодох юм. Бүтээлч, хайр энэрлээр бялхсан, утга учиртай амьдралаар амьдрах хүсэл эсвэл амьдралын төлөөх инстиктээс илүү нарциссизм нь хүний амьдралын хүчирхэг хөдөлгүүр болдог гэдгийг сэтгэл судлаачид илрүүлсэн байдаг. Хэн нэгэн Рамсейгийн тайлбар буруу гэдгийг, объектив үнэлэмж домог биш болохыг, ертөнц физик, хими, биологийн хүрээнд л “хөндий хүйтэн механизм” байдаг болохыг, бид зөвхөн физик, хими, биологийн вант улсад төвхнөн суудаггүй гэдгийг харуулья гэж бодъё. Улмаар уг шинэхэн тайлбар нь шинжлэх ухаанч үзлийн бидэнд олгож буйтай яг адил оюуны үнэмшил бярыг (intellectual confidence), илүү дээр арга зүйтэй гэх ижил санааг, баримт дээр тулгуурласан гэх адил утга бүхий эрх дархыг өгөх юм бол бид уг үзлийг найр тавин хүлээн авна.

Шинэ үзэл ёсоор оюуны бахархал маань хэврэгхэн эд байж, бид эцэг өвгөдөөсөө илүү гарахаар шальтай зүйл

бүтээгээгүй байж тааръя. Үнэмшилтэй эргэцүүлэл (plausible reasoning) хийхэд мадаг дагуулсаар байдаг (fallible) чадамж, үүнтэй хэлхэлдэх тодорхойгүй байдал, сэтгэл хөдлөлдөө автамтгай хандлага, эрх дарх, хувийн сонирхолд хошуурах хошуурлын үр дүнд дийлэнх маань уг үзлийг “шинжлэх ухаанч бус” “бүдэг бүрхэг”, “шийдвэр гаргах хангалттай шалгуур” -аар дутмаг гэх мэтээр хэлж түдгэлзүүлэх болно гэж би тааж байна.

Үнэнийг хэлэхэд дотроо харилцан уялдаагүй (inconsistent), хоорондоо зөрчилтэй (incoherent) байна аа гэдгийг харууллаа ч дийлэнх маань шинжлэх ухаанч үзэлтэйгээ зууралдсаар л байх байх гэсэн хар буух юм. Товчхондоо бид гоц гойд хүмүүс гэх статусаа алдсанаас гутрахыг илүүд үзэх аж.

Би ерөнхийдөө “Оюун, Үнэн ба Түүх” гэх номдоо иймэрхүү шинэлэг санааг бүдүүвчлэн тусгаж, өмгөөлөхийг оролдсон болно. Угаас энэ үзлийг тусгахад хар зургийг л гаргахаас цааш ахих аргагүй учраас би бүдүүвч зургийг л дүрсэлсэн төдий. “Шинжлэх ухааны бус, формал бус мэдлэг” гэдэг гарчигтай сурах бичиг бага зэрэг хөгтэй л байх болно. Гэхдээ XIX зууны сүүл үеэс хойших орчин үеийн үзэл санааны манлайлагчдын хамгийн шилдэг гэсэн бодол, мэдлэг хэмээн тооцогдох сэтгэлд дарамттай уйтай үзлээс илүү зөв чиглэл рүү номын ерөнхий хүрээ хандсан гэдэгт бол итгэлтэй байгаа. Тэгэхээр энэ эсээ бол ерөнхий бүдүүвч зургийн товчхон хар зураг гэсэн үг юм.

В.В.Куайн шинжлэх ухаан нь формал синтактик аргаар урагшилдаг гэх санаа бол домог (myth) гэдгийг онцолсон билээ. Онол нь баримттай зөрчилдөх үед бид заримдаа онолоосоо, заримдаа “баримт”-аасаа татгалздаг. Онол онолтойгоо зөрчилдөх үед мэдэгдэж буй ажиглалтын баримт дээр суурилж үргэлж шийдвэр гаргах аргагүй байдаг. (Туршилт хийж аль нэгийг нь сонгох

тухай бодол хэн нэгний толгойд орохоос даруй тавин жилийн өмнө Эйнштейний таталцлын онолыг хүлээн зөвшөөрч, Уайтхайдын хувилбараас түдгэлзсэн байдаг юм) Заримдаа шийдвэр энгийн байдал (simplicity) (Эйнштейний онол нь Уайтхайдынхтай харьцуулахад харьцангуйн тусгай онолоос таталцал руу шилжих илүү “энгийн” алхам мэт харагддаг), консервативизм (Эйнштейн импульсийг дахин тодорхойлсноор харимхай мөргөлдөөний хүрээнд импульс хадгалагдах хуулийг авч үлдсэн юм.) гэх мэт зорьж хүсэх чанарууд дээр үндэслэх бөгөөд “энгийн байдал”, “консервативизм” зэрэг нь нөхцөл бүрээс хамааран өөр өөр байх нарийн төвөгтэй үзэгдэл билээ. Ажиглалтын өгөгдөл онолын шаардлагатай зөрчилдөх үед эсвэл энгийн байдал ба консерватизм хоёр эсрэг зүг рүү зөрүүдлэх тохиолдолд золиос заавал шаардах бөгөөд, юуг орхих вэ гэдгийг зааварчлах формал дүрэм буюу арга лав байдаггүй. Куайны хэлсэнчлэн бид “рациональ, прагматик” шийдвэр гаргадаг аж.

Миний үндэслэл ёсоор когерент чанар болон энгийн байдал нь өөрсдөө үнэлэмж юм. “Когерент” болон “энгийн” зэрэг нь зүгээр л эмотив (сэтгэл хөдлөлийн) үгс бөгөөд онолд хандах “нааштай хандлагыг (pro attitude)” илэрхийлдэг. Гэхдээ эдгээр үгс нь онолд ямар нэг тодорхой шинж чанарыг оноодоггүй хэмээн үзвээс зөвтгөлийг (justification) бүхэлд нь субъектив асуудал хэмээн тооцох учиртай. Нөгөөтээгүүр “энгийн” болон “когерентыг” “нааштай хандлагатай” хүмүүст хамаатай саармаг шинж чанарын нэр гэж үзлээ ч үүнийг объектив зөв (rightness) гэдгийг шалгах шалгуур байхгүй нь дахиад л асуудал дагуулна.

Парадигм болдог үнэлэмжийн нэр томъёотой (“зоригтой”, “ээлдэг”, “шударга”, “сайн” гэх мэт) адил “когерент” болон “энгийн” зэрэг үгсийг магтаж сайшаахдаа хэрэглэдэг. Үнэхээр ч эд бол үйлдлийг чиглүүлдэг (action guiding)

нэр томъёо юм. Тохиромжтой нөхцөлд онолыг “когерент, энгийн, тайлбарлагч (explanatory)” гэх нь тухайн онолыг хүлээн зөвшөөрөх явдлыг зөвтгөж байгаа хэрэг болно. Бодомжийг (мэдэгдлийг) хүлээн зөвшөөрч байгааг (бүхэлдээ) зөвтгөсөн гэж хэлэх нь тухайн бодомж буюу онолыг хүлээн авах ёстой гэсэн үг юм. Жон Макигийн шаардсанчлан үйлдлийг чиглүүлж буй предикатууд “онтологийн хувьд хачин этгээд (queer)” байлаа ч эпистемологид зайлшгүй шаардлагатай. Цаашилбал когнитив бус ёс зүйн чиглэлд (ёс зүйн нонкогнитивизм) хамаатай үндэслэл бүр өчүүхэн ч өөрчлөлтгүйгээр эдгээр эпистемологийн предикатад ч таардаг: Соёл дотор болон соёл хооронд юуг когерент, юуг энгийн (юуг зөвтгөсөн, юуг үнэмшилтэй гэх мэт) гэх талаар санал зөрөлдөөн байдаг. Зүй ёсны уг чанарын тухай маргааныг шийдвэрлэх ямар хэцүү билээ эдгээртэй холбоотой маргаан яг адил. Зүй ёс юм уу, сайны уг чанарын тухай бидний үзэл түүхэн утгаар хэрхэн нөхцөлдсөнтэй адил, когерент чанар болон энгийн байдлын тухай бидний үзэл ч тийнхүү нөхцөлдсөн. Рациональ чанарын уг чанар нь өөрөө асуудал дагуулах тул дээрхээс алийг нь илүү гэж үзэх рациональ саармаг ойлголт ч байхгүй.

Ричард Рорти “А соёлын стандартын хувьд зөвтгөсөн релятив (justified relative)” нь нэг шинж чанар, “Б соёлын стандартын хувьд зөвтгөсөн релятив” нь өөр нэг шинж чанар гэж хэлж мэдэх л юм. Гэхдээ хэрэв бид тухайн бодомж юм уу онолыг хүлээн зөвшөөрнө гэдэг бол “А соёлын стандартын хувьд зөвтгөсөн релятив” юм гэдгийг баримт гэх аваас бид “соёлын стандарт байх”, “соёлын стандартын дагуу байх” гэдгийг ямар нэг соёлын стандарттай хамааралгүй, объектив ямар нэгэн зүйл гэж үзэж байна гэсэн үг. Ингэх нь ч бидэнд өлзийтэй. Эс бөгөөс бид Протагорын өөрөө өөрийгөө няцаасан релятивизмын ангал руу унана гэж мэд. Протагортай адил бид *зөв байх болон өөрийн зөв гэж бодох* хоёрын

ялгаг хөсөр хаяж таарна. Соёл гэх ойлголт ч бутран унана. (Хүн бүрд ярианы онцлог (идиолект) байдагтай ижил, хүн бүрд өөрийн гэсэн “хувийн соёл (идиокултур)” байх уу? Орчин цагт дэлхийн аль нэг оронд нийт хэдэн “соёл” байгаа вэ?)

“Соёлын стандарт байх” болон “Соёлын стандартын дагуу байх” зэрэг ойлголтууд нь эзэмших тусам хүндрэх (эпистемологийн утгаараа) төвөгтэй ойлголт. Иймэрхүү төрлийн баримтуудыг объектив байдал болон релятив чанарын тухайн яриа хэлэлцүүлэг бүрийн эхлэх цэг хэмээн авч үзэх нь (нийгмийн ухаанаас үүдэлтэй сциентизмийн төрлийг физикээс үүдэлтэй сциентизмийн өөр нэг төрөлтэй эсрэгцүүлэх) жигтэй хачин өвчин гэлтэй. “*Оюун, үнэн ба түүх*”-д дурдсанчлан, когерент чанар, энгийн байдал, инструментал үр нөлөө зэрэг танин мэдэхүйн үнэлэмжгүйгээр бид ертөнц үгүй, баримт ч үгүй, бүр юу юутай ямар хамааралтай тухай ч баримтгүй хоцорно гэж мэд. Эдгээр танин мэдэхүйн үнэлэмжийг хүн төрөлхтний хөгжил цэцэглэлтийн тухай бидний холистик ойлголтын нэг хэсэг гэж тунхаглаж байгаагаа дуулгая. Үнэн бол “корреспондент чанар” гэх хуучны реалист санаа, зөвтгөл бол олон нийтээр тогтоогддог “шалгуур” гэх позитивист үзэлдээ баяртай гэж хэл. Донтож дурлан түүнийгээ дагаснаас л аливаа үйл явц эхэлдэгтэй ижил, рациональ чанарын тухай илүү дөмөгхөн ойлголтыг эрэлхийлэх эрэл хайгуулыг сайн гэх бидний ойлголтоор баримжаагаа хийсэн интенционал (зорилгот) үйл явц хэмээн үзэх зайлшгүй шаардлага л бидэнд үлдэж дээ.

Гэхдээ байз. Төлөгчлөгч (predicative) онолуудаас аль нэгийг нь сонгож буй тохиолдлоор когерент чанар ба энгийн байдлыг хязгаарлаж болох уу? Ямар нэгэн шинэ зүйл хэлэхгүй бол танин мэдэхүйн ач холбогдолгүй гэж Логик позитивизм үздэг. Гэхдээ энэ нь тойруу утгаараа бол (эмпирицист философид) бидний

эпистемологийн эхлэх цэг нь сэрлийн өдөөгчид (sensory stimulations) гэдгийг төлөгчилж буй хэрэг юм. Тойруу утгаараа ч байсан аливааг төлөгчлөх бидний чадварыг сайжруулахад энэхүү бодомж ямар ч нэмэргүй. Хязгаар тавьсан нөхцөлтэй эсвэл шинжлэх ухааны хуультай, нэг бол тохирох математиктай, үгүй бол бүгдэнтэй нь нэгэн зэрэг зэрэгцүүлээ ч позитивист төдийгүй өөр ямар ч философиос ажиглалтын өгүүлбэр урган гарахгүй. Товчхондоо позитивизм өөрөө өөрийгөө няцаадаг юм. Эргэцүүллийн гол зорилго буюу функцийг төлөгчлөл (эсвэл төлөгчлөл дээр нэмэх нь “энгийн байдал”) гэх нь өрөөсгөл хандлага юм. Уг хандлагыг нотлохын тулд эхлээд оюуны сонирхол төлөгчлөлтэй огт хамаагүй гэх урьдач санааг дэмжих хэрэг гарна. Эндээс л утга учиргүй, үндэслэл муутай байгаа нь илрээд гараад ирнэ. (Мартсанаас манай үеийн шинжлэх ухааны философийн хамгийн нөлөө бүхий хоёр хандлага болох релятивизм ба позитивизм нь аль аль нь өөрийгөө няцаадаг гэдгийг “*Рационал чанарын тухай хоёр ойлголт*” гэх номынхоо нэг бүлэгт үндэслэж бичсэн байгаа.)

Когерент чанар, энгийн байдлыг үнэлэмж гэе. Тэгвэл өөрийгөө няцаагч субъективизм рүү хандалгүйгээр тэднийг объектив (“зөөлөн чанар (softness)”, сайтар тодорхойлсон “шалгуур” үгүй байдал зэргийг нь тэвчихгүйгээр) болохыг үгүйсгэж чадахгүй байх аваас ёс зүйн үнэлэмжийн объектив чанарын эсрэг сонгодог үндэслэлүүд бүхэлдээ хүчин мөхөсдөнө гэсэн үг. Ёс зүйн үнэлэмжийн “зөөлөн чанар”, маргаангүй “арга” байдаггүй зэрэг болон *үйлдлийг чиглүүлдэг баримтын* сэжиг бүхий “хачин этгээд байдал”-ын эсрэг тухайн үндэслэлүүд чиглэдэг. Гэхдээ бүх үнэлэмж л нэг завин дээр хөвж байдаг: Хэрэв эдгээр үндэслэлүүд нь ёс зүйн үнэлэмж бүхэлдээ субъектив гэдгийг нотлох аваас танин мэдэхүйн үнэлэмж ч мөн бүхэлдээ л субъектив байж таарна.

Тэгвэл бид чинь хаана яваа хэрэг вэ? Нэг талд шинжлэх ухаан (яг цэвэр шинжлэх ухаан) рациональ чанараа шавхсан гэдэг нь өөрөө өөртэйгөө зөрчилдөх алдаа мэт. Рациональ чанарын уг чанарын тухай маргаан нь рациональ чанар гэх ойлголт нь лабораторид шалгагдах чанараас илүү өргөн хүрээг хамардаг гэх урьдач төсөөллийг төрүүлнэ. Төлөгчлөлгүйгээр юуг шалгаж болохгүй талаар баримт үгүй бол үүнийг өөрийг нь багтаасан философийн бодомжийн тухай ч баримт байх учиргүй. Нөгөө талаас хэл шинжлэл, менталист сэтгэл судлал, түүх, клиник сэтгэл судлал зэргийг дурдалгүйгээр философийг өөртөө багтаагаад авах өргөн хүрээний рациональ чанарын тухай аливаа ойлголт нь уг ойлголт маань өөрөө угтаа бүдэг бүрхэг, тодорхой бус, өвөг дээдсийн маань мэдлэгээс илүү “шинжлэх ухаанжсан” байж дийлэхгүй гэдгийг ч мөн багтаах хэрэг гардаг. “Аргагүйчилж” болохгүй зүйлс бол юу ч биш гэх айдас нь аргын фетишизм төдий л эд шүү дээ. Үүнийг даван туулах цаг аль хэдийн болсон. Ийнхүү алхам урагшилснаар эсээний эхэнд дурдсан, оюуны хөөсөрсөн ихэрхлийг намжаах болно. Магадгүй нууцлаг байдлын тухай ойлголтоо дахин сэргээж ч болох юм. Хэн мэдэх вэ?

Олонд түгсэн философийн номлол нь утга авцалдаагүй буюу бүр долоон дор гэж маргахдаа би дуртай байдаг. “Оюун, үнэн ба түүх” номдоо үнэний тухай хамгийн нөлөө бүхий онолууд болох эмпирицист онол (гол зорилго нь “сэрлийн өгөгдлийг (sense data)” зөв хүртэх тухай асуудал л байдаг. Өмнө дурдсан Рамсейгийн эшлэлд ч Рамсей энэ санааг баримталсан болохыг анзаарна уу) болон корреспондент баримтлал (Үг болон объектийн хооронд онцгой “корреспондент чанар” байдаг бөгөөд энэ нь референц болон үнэний оршихуйг тайлбарлана) нь тайлбарлагч шинжгүй эсвэл огтоос ойлгомжгүй эд гэдгийг дэлгэн харуулахыг зорьсон болно.

Энэ хүртэл юу хүүрнэснээ нэгтгэн товчловоос, хэрэв шинжлэх ухааны явцуу үзлийн үүднээс “үнэлэмж” сэжигтэй санагдах бол, дор хаяж л зөвтгөл, когерент чанар, энгийн байдал, референц, үнэн гэх мэт маш олон “хам хэрэгтнүүд” гарч ирэх бөгөөд, эпистемологийн үүднээс бол эд бүгд сайн болон сайхан сэтгэлтэй яг ижил асуудал дагуулах болно. Алийг ч физик ойлголт руу буулган танаж болохгүй, аль нь ч яг таг синтактик дүрэмд захирагдахгүй. Бүгдийг нь таягдан хаях (бодох болон ярих үйлийг бодлоосоо авч хаяна гэсэн үг) буюу оюуны зөвтгөл үгүй, инструменталист явцуу рациональ чанарын хүрээнд үл тохирох зарим хэдээс нь татгалзах гэсэн яг одоо эрхэлж буй үйлийнхээ оронд, хүн төрөлхтний хөгжил цэцэглэлт, оюун ухааны тухай үзэл санаа (**idea of reason**) нь бүх үнэлэмж, танин мэдэхүйн үнэлэмжийн эрх дархыг ханган бататгаж, арчлан тордож байдаг гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хөгжил цэцэглэлт, оюун ухаан гэх хоёр санаа нь хоорондоо уялдаатай агаад, тэмүүлж буй онолын ухаан маань үнэн хэрэгтээ зорьж буй хүний хөгжил цэцэглэлтийн л нэг хэсэг байдаг бөгөөд үүнийг Плато, Аристотель нарын үзсэн нийтлэг идеалаас сугалж гаргах ямар ч хэрэггүй юм.

Дүгнэн хэлэхэд физик ертөнц бол зарим утгаараа “халамж хайр” үгүй (“хөндий хүйтэн” гэдэг нь бага зэрэг будлиан тарьж мэдэх ч гэсэн) машин гэдэгт би огтхон ч эргэлзэхгүй байна. Гэхдээ Кантын хэлсэнчлэн физик ертөнц гээж үлдээж буй тэр зүйлс нь ертөнцийг бидний хувьд боломжит болгож буй тэр юмс буюу интенциональ, үнэлэмжит, референт бүхий ажил хэргийн “синтез” болж, “сэрлийн өдөөгчөөрөө” ертөнцийг бүтээн босгох боломжийг олгож буй тэдгээр зүйлс юм. Товчхондоо үнэлэмжгүйгээр бидний хувьд ертөнц гэж байхгүй гэж үзэж буйгаа уламжилъя. Үүнийг инструментализм няцаадаг авч, өөрөө ч мөн л үнэлэмжийн систем билээ. Алдаатай л болохоос.